

“МОНГОЛ АЛТ” ХК

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/			
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.			
Тайлагнах хугацаа	2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31 өдөр		
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	“МОНГОЛ АЛТ” ХК УБГД:1910010005 ҮЦКод: 68 Утасны дугаар: 70373263		
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж ХК		
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Геологийн судалгаа, барилгын худалдаа, үйлчилгээ		
Жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Бэйкер Тилли Даливан Аудит ХХК, 1993		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	265,852.00 ширхэг		
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга С.Бат-Эрдэнэ Хянасан: Гүйцэтгэх захирал М.Цолмон		
1. Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана.			
Санхүүгийн тайлан	Үзүүлэлт	1/1/2024	12/31/2024
	ХӨРӨНГӨ		
	Эргэлтийн хөрөнгө	4,584,667,247.44	4,654,209,819.15
	Эргэлтийн бус хөрөнгө	5,858,156,245.40	14,932,463,694.36
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	10,442,823,492.84	19,586,673,513.51
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
	Богино хугацаат өр төлбөр	9,668,083,544.63	18,622,028,362.97
	Урт хугацаат өр төлбөр	-	-
	Эздийн өмч	744,739,948.21	964,645,150.54
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	10,442,823,492.84	19,586,673,513.51
Орлогын тайлан Үзүүлэлт	Үзүүлэлт	1/1/2024	12/31/2024
	Борлуулалтын орлого (цэвэр)	1,480,238,003.19	398,853,322.13
	Борлуулалтын өртөг	423,879,629.74	-
	Нийт ашиг (алдагдал)	1,013,075,369.24	398,753,322.13
	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	75,533,375.30	211,005,780.36
	Орлогын татварын зардал	7,553,337.53	21,100,578.03
	Тайлант үеийн ашиг (алдагдал)	67,980,037.77	189,905,202.33
	Орлогын нийт дүн	67,980,037.77	189,905,202.33

Өмчийн өөрчлөлтийн тайлан	Үзүүлэлт		1/1/2024	12/31/2024
	Өмч		26,585,200.00	26,585,200.00
	Хуримтлагдсан ашиг		748,154,748.21	938,059,950.54
	Нийт эздийн өмчийн дүн		774,739,948.21	964,645,150.54
Мөнгөн гүйлгээний тайлан			1/1/2024	12/31/2024
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(4,476,704,993.11)	(1,392,215,993.89)
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(1,918,822,350.92)	(359,002,387.83)
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		6,412,684,439.64	2,081,267,723.02
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		17,157,095.61	329,949,341.30
	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ		22,867,007.61	40,024,103.22
	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ		40,024,103.22	369,973,444.52
1.1 Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт /хавсргав/				
1.2 Аудитын тодорхойлох захидал /хавсаргав/				
2. Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинэжилгээ, орлого зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт /хавсаргав				
2.1	Үйл ажиллагааны үр дүн / санхүүгийн харьцааны үзүүлэлтзүүд	Нийт ашгийн хувь 0.47 Эздийн өмчийн өгөөж /ROE/ 0.2 Нийт хөрөнгийн өгөөж /ROA/ 0.009		
2.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа 0,85 Түргэн хөрвөх чадварын харьцаа 0,83 Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа 4,25		
2.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл,бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	Одоогоор гадаад орчны нөлөөлөл байхгүй байна.		
2.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй		
2.5	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны мэдээлэл	“Хаан банк” ХК-иас 2024 оны зээлсэн 1.3 тэрбум төгрөгийг бүрэн төлж барагдуулан, барьцаа хөрөнгийг бүрэн чөлөөлсөн.		
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/ -байхгүй			
4.	Цалин урамшууллын мэдээлэл Цалин урамшууллыг үнийн өсөлттэй уялдуулан компанийн нөөц бололцоо, бодлогод тулгуурлан нэмэгдүүлж байна.			

5.

Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл
Компанийн засаглалыг сайжруулах чиглэл тогтмол анхаарч, шинээр ажилд авч байгаа залуу мэргэжилтнүүдийг дэмжих, сургалтад хамруулан дэмжисж байна. Төслийн удирдлагын чадварлаг баг бүрдүүлэх тал дээр онцгой анхаарч байна.

ТУЗ-ийн үүрэг
Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн үйл ажиллагааны үр дүнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээдэг.
ТУЗ гүйцэтгэх захирлын ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх томилох, дотоод хяналт, эрсдлийн удирлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах зэрэг үүрэгтэй.
ТУЗ-ийн хороод
“Монгол Алт” ХК ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий байнгын 3 хороотой ба эдгээр хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болгох зорилгоор санал дүгнэлт гаргах үндсэн зорилготой. Хороодын үйл ажиллагааг “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-аар зохицуулдаг.
ТУЗ нь дараах байнгын хороодтой:

- Нэр дэвшүүлэх хороо
- Аудитын хороо
- Цалин, урамшууллын хороо

ТУЗ –ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болно. Компанийн тухай хуульд ТУЗ-ийн хараат бус гишүүн нь аудитын хороонд ажиллахаар заасан байдаг.
“Монгол Алт” ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 06-нй өдрийн 02 тоот тогтоолын дагуу “Монгол Алт” ХК -ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулсан.
ТУЗ-ийн дарга:
Л.АМАРСАНАА
ТУЗ-ийн ердийн гишүүд:
Ж.МӨНХТӨР
М.ОЮУН
М.ЦОЛМОН (гүйцэтгэх захирал)
Б.ЦЭЛМЭГ
А.МОЛОР-ЭРДЭНЭ
ТУЗ-ийн хараат бус гишүүд:
С.ДОРЖДЭРЭМ
Л.БАЗАРСАД
О.ЛУВСАНШАРАВ
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:
ТУЗ үйл ажиллагаагаа хэвийн явуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах зорилгоор ТУЗ-д шууд хариуцлага хүлээх нарийн бичгийн даргыг томилох үүрэгтэй. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар С.Бат-Эрдэнэ ажиллаж байна.

6.

Зээлийн эрсдлийн мэдээлэл- Эрсдэл байхгүй

7.

№	Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо	Хувьцааны эзлэх хувь
1	Мөнхтөрийн Цолмон	12067	4.5
2	Лувсандагвын Амарсанаа	17612	6.6
3	Батмөнхий Саруул	26860	10.1
4	Минээгийн Оюун	39388	14.8
5	Мөнхтөрийн Жавхлан	35399	13.3
6	Жамбалын Мөнхтөр	62338	23.4
7	Жамсранжавын Мягмаа	5966	2.2
8	Базарсадын Батром	560	0.2
9	Амарсанаагийн Болор-Эрдэнэ	17134	6.4
10	Амарсанаагийн Молор-Эрдэнэ	17600	6.6
11	Лувсанжамцын Базарсад	1112	0.4

	12	Амарсанаагийн Болортуяа	17634	6.6	
	Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо 145				
	Нийт хувьцааны тоо		265852	100	
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.				
9.	Ногдол ашигийн мэдээлэл - Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дугаар сарын 28-ны өдрийн хурлаар ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар нэгж хувьцаанд 370 (гурван зуун дал) төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар тогтоосон.				
10.	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажил байхгүй болно.				
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:					
Овог, нэр: Мөнхтөрийн Цолмон Албан тушаал: “Монгол Алт” ХК-ийн Гүйцэтгэх захирал Гарын үсэг: (тамга, тэмдэг)					
Мэдээлэл бэлтгэж хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:					
Овог, нэр: С.Бат-Эрдэнэ Албан тушаал: “Монгол Алт” ХК-ийн ТУЗ-ийн НБД Гарын үсэг: Огноо: 2024.06.20					



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“МОНГОЛ АЛТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Санал дүгнэлт

Бид 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Монгол Алт” ХК-ийн санхүүгийн тайланд аудитыг хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Монгол Алт” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого, зардал, үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартаар нийцүүлэн үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг “МНБ-ын ёс зүйн дүрэм”-г мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалтай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн ихээр анхаарал татсан асуудал байдаг. Бидний гаргасан тайланд нөлөөлөхүйц аудитын гол асуудал тодорхойлоогүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй. Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН **(үргэлжлэл)**

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй болно.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид:

- ✓ Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Гэхдээ алдаанаас бус компанийн үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөхийг зориогүй.
- ✓ Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

- ✓ Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхад материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт бид анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- ✓ Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад дотоод хяналтаас хэрэгжүүлж буй асуудлуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайланд харуулсан.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг Монгол улсын Компанийн тухай хуулийн 95.1-р зүйлд заасан хуулийн этгээд болох “Монгол Алт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.


БЭЙКЕР ТИЛЛИ
ДАЛАЙВАН АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2025 ОНЫ 03 ДУГААР
САРЫН 14-НЫ ӨДӨР